



## ТЭГШ САН-АУДИТ ХХК

НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ, АУДИТ, ХЯНАЛТЫН  
ИТГЭМЖЛЭГДСЭН БАЙГУУЛЛАГА

Ховд аймаг, Жаргалант сум  
Утас: 9543-8030

2020 он 02 сар 07 өдөр № ...06

**“Алтайн Нэгдэл” ХК-ийн  
Захирал Б. Ганболд танаа**

### ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

Бид “Алтайн Нэгдэл” ХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний санхүүгийн байдлын тайлан, жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан ач холбогдол өндөртэй нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тэмдэглэлээс бүрдсэн санхүүгийн тайлангуудад аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний үзэж байгаагаар эдгээр санхүүгийн тайлангууд нь бүхийл материаллаг асуудлаар “Алтайн Нэгдэл” ХК-ний 2019 оны 12-р сарын 31-ийн байдлаар санхүүгийн байдал, тухайн жилийн санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг харгалзах санхүүгийн тайлагналын үзэл баримтлалд нийцүүлэн шударгаар илэрхийлсэн байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг АОУС-ын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагаа энэ тайлангийнхаа “Санхүүгийн Тайлангийн Аудитад хүлээх Аудиторын Үүрэг Хариуцлага” гэсэн хэсэгт харуулав. Бид “Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Дүрэм”-ийн санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой зохих ёс зүйн шаардлагуудын дагуу компанаас хараат бусаар, ёс зүйн шаардлагуудад нийцүүлэн ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Олж авсан аудитын баримт нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай, тохирхонжтой гэж итгэж байна.

#### Аудитын Гол Асуудлууд

Бидний мэргэжлийн шүүмжээр аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудититад хамгийн их нөлөөтэй асуудлууд юм. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлыг нэгтгэсэн

байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн тусдаа дүгнэлт гаргаагүй болно.

#### **Удирдлагын Санхүүгийн тайлангийн үүрэг хариуцлага**

Удирдлага нь СТОУС-ын дагуу эдгээр санхүүгийн тайланг бэлтгэх үнэн зөв толилуулах хариуцлага хүлээнэ. Мөн залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаагүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэхийн тулд зайлшгүй гэж үзсэн дотоод хяналтуудын талаарх хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайлангуудаа гаргахдаа удирдлага тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах компанийн чадамжийг үнэлэх, тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэгжүүлэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хүлээнэ.

#### **Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага**

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ анги эсэх талаарх ул үндэслэлтэй нотолгоо олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний үүрэг юм.

Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшиний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлдэг гэсэн нотолгоо болохгүй. Буруу илэрхийлэх явдал нь залилан эсвэл алдаанаас үүсч болох ба тэр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогддог.

Компанийн дотоод хяналтын үр ашигтай байдалд дүгнэлт өгөх зорилгоор бүр тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитын ажилтай холбоотой дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг. НББ-ын нийлэмжтэй байдал, НББ-ийн тооцооллын үндэслэл, удирдлагын гаргасан холбогдох тодруулагыг үнэлдэг. Аудиторын тайлан гарах өдөр хүртэлх олж авсан аудитын баримт нотолгоондоо үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг.

“Алтайн Нэгдэл” ХК -ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан нь Монгол Улсад зөвшөөрөгдсөн нягтлан бодох бүртгэлийн зарчмын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн учир зөрчилгүй дүгнэлт өгч байна.

Захирал



Б.Баясгалан